

**ОУИТБС-ын төрөлжсөн 3-р ажлын хэсгийн
хурлын тэмдэглэл**

Огноо: 2015 оны 5 дүгээр сарын 22, 14 цаг

Хурал болсон газар: Сангийн яам, хурлын танхим

Ирц: Ажлын хэсгийн ахлагч Б.Болормаа, гишүүд Г.Зулай, Д.Энхтуяа, Н.Оюунцэцэг, Г.Ганбат нарын бүрэлдэхүүнтэй буюу ажлын хэсгийн нийт 11 гишүүнээс 5 хүрэлцэн ирж, ...% ирцтэй хуралдав.

Хурлыг ажлын хэсгийн ахлагч Сангийн яамны НББГ-ын ахлах мэргэжилтэн Б.Болормаа удирдан явуулав. Хурлын ирц болон өмнөх хурлын шийдвэрийн дагуу хийсэн ажлыг Г.Ганбат танилцуулснаар хурал эхлэв.

1. Ажлын явц тус бүрээр хийсэн ажил
2. Ажлын хэсгийн санал дүгнэлтийн тухай

Хэлэлцсэн асуудал 1. *Маягтад өөрчлөлт оруулах тухай*

Өмнөх хурлын шийдвэрийн дагуу судлахаар болсон үзүүлэлтүүдийн талаар танилцуулав.

- Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн дүнг төрийн захиргааны байгууллага, орон нутаг 2 төлж байгаа Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтуудыг танилцуулав.
- Газрын тосны газарт байршуулдаг 3% ийн барьцаа төлбөрийн талаар Газрын тосны хуулийн холбогдох заалтыг танилцуулж, маягтад нэмэхээр тохиров.
- Маягтын үзүүлэлтүүдийг 1000 төгрөгөөр биш төгрөгөөр тайлагнах болов
- Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, туршилтын олборлолт үзүүлэлтийн үйлдвэрлэсэн үнийн дүнг Үйлдвэрлэсэн өртөг гэж өөрчлөх

Хэлэлцсэн асуудал 2. Маягтын зааврыг боловсронгуй болгох

Маягтын зааврын одоогийн хувилбарыг 2012 оны ОУИТБС-ын нэгтгэл тайлан дахь маягтын үзүүлэлтүүдтэй харьцуулан сонголт хийж боловсронгуй болгох

Хэлэлцсэн асуудал 3. Аудитын нэгтгэлээр гарган өгөх нэмэлт мэдээллийн жагсаалт гаргах, түүнд тохирсон маягт боловсруулах, аудитын ажлын даалгаварт оруулах

Нэгтгэл тайланд ил тод болгох ёстой 11 мэдээлэл байгааг жагсааж, боловсруулсан маягтуудыг танилцуулав.

Ашигт малтмалын газрын төлөөлөл дахин нягталж дэлгэрэнгүй санал өгөхөөр болов.

Хэлэлцсэн асуудал 4. Засгийн газрын мэдээлэл цуглуулах процессийг нягтлах

Тус ажлын хүрээнд хийсэн судалгааг танилцуулж, санал дүгнэлтийн төслийг танилцуулж дэмжив.

Хэлэлцсэн асуудал 5. Төрийн байгууллагын болон Компаниудын тайланг аудитаар баталгаажуулах

Үндэсний аудитын газраас дэлгэрэнгүй тодруулга авахаар ажиллаж байна.

Мөн ажлын хэсгийн нэгдсэн санал дүгнэлтийн төсөлд гишүүдээс санал өгч, эцсийн хувилбарыг бэлтгэхээр тохиролцов.

Тэмдэглэл бичсэн: Ажлын хэсгийн нарийн бичиг Г.Ганбат